



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/233

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 4.5.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.2, 4.2.9, 5.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах Ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдээс тодорхой үр дүнд хүрээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа ажлуудын шалтгааныг судалж, холбогдох арга хэмжээ авч эрчимжүүлэх, үр дүнг сар бүр Иргэний нисэхийн үндэсний төвийн даргад танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (И.Амарсанаа), нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тус төвийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дахин хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Дотоод хяналтын алба (И.Амарсанаа)-нд үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны ᠙.᠖. дугаар сарын ᠘.᠘ -ны өдрийн
А/᠒33. дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Дотоод хяналтын албаны дарга И.Амарсанаа
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Р.Амарбаясгалан
Ажлын хэсгийн гишүүд:	Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга Э.Төрбаяр
	Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга С.Нацагдорж
	Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга У.Өнөрцэцэг
	Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын дарга Б.Батхишиг
	Нисэх буудлуудын бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн дарга М.Даваажав
	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны дарга П.Пүрэвсүх
	Холбоо навигаци, ажиглалтын албаны дарга М.Эрдэнэсүх
	Нисэхийн сургалтын төвийн захирал Б.Урантөгс
	Ерөнхий зориулалтын нисэхийн албаны дарга Г.Цолмон
	Мэдээлэл, технологи инновацийн албаны менежер Ц.Ган-Эрдэнэ
	Дотоод хяналтын албаны мэргэжилтэн Ж.Минжүүр
	Агаарын навигацийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Б.Уянга
	Захиргааны хэлтсийн захиргаа, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Долгио